



ЗАЛУУ СУДЛААЧДЫГ
ДЭМЖИХ САН
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА



TUSS
Tailored Unified System Solution



“БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ДҮРЭМ, ЖУРМУУДЫН ХООРОНДЫН УЯЛДАА
ХОЛБООГ ҮНЭЛЭХ, САЙЖРУУЛАХ
СИСТЕМИЙН ШИЙДЛҮҮД”



Сургалтын зорилго, агуулга, сургагч багшийн танилцуулга



Д.Жаргалсайхан
ЗСДС ТББ-ын тэргүүн

Сургалтын зорилго:

Байгууллагын үйл ажиллагааны дүрэм, журмын уялдаа холбоог үнэлэх, сайжруулах системийн инженерчлэлийн аргуудыг тайлбарлах, хэрэглүүлэх замаар зорилгоо хэрэгжүүлэх чадвартай систем болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх

Сургалтын агуулга:

1. Дүрэм, журам гэдэг ойлголтыг танин мэдэх нь
2. Дүрэм, журмыг уялдуулах суурь зарчим
3. Дүрэм, журмын хэрэгжилтийг хангах арга
4. Дүрэм, журмыг дижиталжуулах нь



1. “ДҮРЭМ, ЖУРАМ ГЭДЭГ ОЙЛГОЛТЫГ ТАНИН
МЭДЭХ НЬ”



Бодлын хэлэхээс:

1. Байгууллага гэж юу вэ? **4-5 хуудас**
2. Зорилго гэж юу вэ? **6-9 хуудас**
3. Үйл ажиллагаа гэж юу вэ? **10-12 хуудас**
4. Үүрэг гэж юу вэ? **13 хуудас**
5. Дүрэм журам гэж юу вэ? **14-16 хуудас**
6. Дүрэм журмыг уялдуулах шийдэл **17-18 хуудас**
7. Дүрэм журамд тулгардаг асуудлууд **19-23 хуудас**
8. Дүрэм журмуудыг уялдуулах зарчим **25-27 хуудас**
 - Дүрэм, журмуудын харилцан уялдааг бүрдүүлэхэд баримтлах суурь шалгуур хэв шинжүүд:
 - Журмын зорилгыг дүрмийн заалттай уялдуулах арга
9. Дүрэм журмуудыг уялдуулах арга **28-35 хуудас**
 - 40 хэв шинжээр шинжилгээ хийх арга
 - Чанартай үүргийн хэв шинжийг бүрдүүлэх


БАЙГУУЛЛАГА ГЭЖ ЮУ ВЭ?

Байгууллага гэж ...

Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэхэд харилцан уялдаатай үүрэг гүйцэтгэж, үр шим хүртэх зорилготой хүмүүсийн цэгцтэй үйл ажиллагааны бүтэц

“ЗСДС” ТББ

Тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд зайлшгүй гүйцэтгэдэг бүлэг үйлдлүүд:



Байгууллагын үйл ажиллагаа нь оролцогч талуудын нэгдмэл зорилгод захирагдана.



Нэгдмэл зорилгын суурь хэв шинжүүд:

1. Оролцогч талуудын нийтлэг ашиг сонирхлыг тусгасан байх ёстой.
2. Оролцогч талуудад нэг мөр ойлгогддог байх ёстой.
3. Зорилгыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байх ёстой.
4. Зорилгын үр дүнг хэмжих боломжтой байх ёстой.
5. Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг тодорхойлсон байх ёстой.

Оролцогч талууд нөөцөө харилцан солилцож байж нэгдмэл зорилгыг хэрэгжүүлнэ.

Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь нөөцүүд:


1. Цагийн нөөц
2. Мэдлэгийн нөөц
3. Санхүүгийн нөөц

Зорилго тогтвортой хэрэгжүүлэх чадвартай үйл ажиллагааны загвар / ТУС /



Тохиргоотой Угсардаг Системийн загварыг ашиглан дүрслэв.

ЗАХА-5 (Зорилгыг албадан хэрэгжүүлэх 5 аксиом)



Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны загварыг 5 аксиом дээр суурилсан ТУС тогтолцооны загварыг бүрдүүлсэн.


1. Нэгдмэл зорилготой байх




2. Үүрэг хүлээдэг байх



3. Мэдээллийг түгээдэг байх



4. Хэмждэг байх




5. Тасралтгүй сайжруулдаг байх



Үйл ажиллагаа гэж юу вэ?

Үйл ажиллагаа



Зорилго

Үйл ажиллагаа гэж ...

Зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн харилцан уялдаатай цогц үйлдлүүд

“ЗСДС” ТББ

Үүрэг бол албажуулсан үйлдэл мөн.



1.82 секунд

Зорилгоруу чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд оролцогч талуудыг үүрэгжүүлэх шаардлагатай.

Үйлдлүүдийг дүрэм, журмаар тодорхойлж заавал гүйцэтгэх хэв шинжийг бүрдүүлнэ.



- Дүрэм гэж юу вэ?
- Журам гэж юу вэ?
- Дүрэм, журам нь хоорондоо хэрхэн уялддаг вэ?

Дүрэм гэж ...

Байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл зорилго, оролцогч талуудын нийтлэг үнэт зүйлс, зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчмууд болон зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь бүтцийг тодорхойлж хооронд нь уялдуулсан, албан ёсоор баталгаажуулсан үзэл баримтлал

“ЗСДС” ТББ

Байгууллагын дүрэмд зайлшгүй тусгагдах оюуны шийдлүүд:

1. Тухайн байгууллагын туйлын болон хэтийн зорилго
2. Тухайн байгууллагын үнэт зүйлс
3. Тухайн байгууллагын зарчим
4. Тухайн байгууллагын үйл ажиллагааны суурь бүтэц

Журам гэж ...


Байгууллагын нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тодорхой функцийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагддаг оюуны болон биет үйлдлүүдийг тодорхойлох, хооронд нь уялдуулах, хэрэгжүүлэх, мониторинг хийхэд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг болон харилцааг зохицуулсан цогц оюуны шийдэл

“ЗСДС” ТББ


Байгууллагын журамд зайлшгүй тусгагдах оюуны шийдлүүд:

1. Тухайн байгууллагын ажилтнуудын зайлшгүй гүйцэтгэх үйлдлүүдийг уялдуулж тодорхойлсон байх
2. Тухайн байгууллагын ажилтнуудын гүйцэтгэсэн үйлдлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай аргачлалыг тодорхойлсон байх
3. Тухайн байгууллагын ажилтнуудын үүргийн гүйцэтгэлд мониторинг хийх шийдлийг тусгасан байх

**Дүрмээр тогтоосон
байгууллагын үзэл баримтлалыг
хэрэгжүүлэхэд оролцогч
талуудын гүйцэтгэх үйлдлүүдийг
журмаар зохицуулна.**



Нэгж журам нь дүрэмтэй уялдахаас гадна журмууд нь хоорондоо уялдсан байх ёстой.



Дүрэм, журмыг хэрэгжүүлэх
явцад ямар асуудлууд тулгардаг
вэ?

Дүрэм, журмыг хэрэгжүүлэх явцад тулгардаг асуудлууд:

1. Дүрэм журамтай танилцахгүй байх
2. Дагаж мөрдүүлэхгүй байх
3. Зөрүүтэй ойлголцол бий болох
4. Дүрэм журам нь үйл ажиллагааг бүрэн хамрахгүй байх.
5. Журмын нийцлийг хянах мониторинг хийх нэгж тодорхойгүй байх.
6. Хэт задгай олон зүйлийг нуршиж бичсэн байдаг.
7. Дотоодод тогтоосон зарим хэм хэмжээ тодорхой биш байдаг.
8. Бусад дүрэм журамтай хэрхэн уялдаж байгаа талаар холбоос байдаггүй
9. Дүрэм, журмын уялдааг хангадаггүй,
10. Баталсан дүрэм, журмыг хэрэглэгчдэд хүргэж, ойлгуулж чаддаггүй,
11. Зохицуулж буй үйл ажиллагаагаа сайн ойлголгүй дүрэм журам боловсруулах гэж оролддог,
12. Баталсан дүрэм, журмыг хэрэглэх заавар, аргачлал дутмаг
13. Баталсан журмыг хэрэгжүүлэх ойлголт, хандлага сул, хэрэгжилтэд байнгын хяналт тавих тогтолцоо ойлгомжгүй



Дүрэм, журмыг хэрэгжүүлэх явцад тулгардаг асуудлууд:

1. Байгууллагын үйл ажиллагааг шинэчилэх, аливаа өөрчлөлтийг хийх явцад эсэргүүцэлтэй тулгардаг.
2. Дүрэм, журмын талаарх мэдлэг дутмаг, мэдэх оролдлого хийдэггүй.
3. Дүрэм, журмын зорилго, хамрах хүрээ, зохицуулалтыг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан, оновчтой тодорхойлж чаддаггүй тул зөрчилдөөн үүсдэг.
4. Дүрэм, журмыг боловсруулахдаа хэт нарийн төвөгтэй эсвэл хоёрдмол утгатай байх зэрэг алдааг гаргасан байдаг тул ойлгомжгүй байдлыг үүсгэдэг.
5. Дүрэм, журмыг тууштай хэрэгжүүлж чаддаггүй.
6. Дүрэм, журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой суурь бэлтгэлийг хангаагүй байдаг тул хэрэгжүүлэх явцад нөөцийн хомсдол үүсдэг.
7. Дүрэм, журам нь байгууллагын соёл, үнэт зүйлстэй нийцүүлэн боловсруулаагүй байдаг.
8. Ажилчид болон гол оролцогч талууд дүрэм, журмыг боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцдоггүй тохиолдолд тэдгээрийг дэмжих эсвэл дагаж мөрдөх тохиолдол багасдаг.
9. Хэт олон дүрэм, журам нь инновацийг боомилж, шийдвэр гаргах явцыг удаашруулж, хүнд суртлыг нэмэгдүүлдэг.
10. Хууль эрх зүйн болон салбарын хөгжлийн улмаас дүрэм, журмын зохицуулалтуудад өөрчлөлт орох шаардлага гардаг. Тухайн өөрчлөлтийг цаг тухай бүрт нь хийж чадаагүйгээс дүрэм, журмын хэрэгжилт саардаг.

Эдгээр асуудлууд яагаад
үүсч байна вэ?



Зорилгын тайллын дэд тогтолцоо:

1. Дүрэм, журам нь байгууллагын соёл, үнэт зүйлстэй нийцүүлэн боловсруулаагүй байдаг.
2. Дүрэм, журмыг боловсруулахдаа хэт нарийн төвөгтэй эсвэл хоёрдмол утгатай байх зэрэг алдааг гаргасан байдаг тул ойлгомжгүй байдлыг үүсгэдэг.
3. Дүрэм, журмын зорилго, хамрах хүрээ, зохицуулалтыг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан, оновчтой тодорхойлж чаддаггүй тул зөрчилдөөн үүсдэг.

Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо:

1. Ажилчид болон гол оролцогч талууд дүрэм, журмыг боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцдоггүй тохиолдолд тэдгээрийг дэмжих эсвэл дагаж мөрдөх тохиолдол багасдаг.

Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо:

1. Дүрэм, журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой суурь бэлтгэлийг хангаагүй байдаг тул хэрэгжүүлэх явцад нөөцийн хомсдол үүсдэг.
2. Дүрэм, журмыг тууштай хэрэгжүүлж чаддаггүй.
3. Дүрэм, журмын талаарх мэдлэг дутмаг, мэдэх оролдлого хийдэггүй.

Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо:

1. Баталсан журмыг хэрэгжүүлэх ойлголт, хандлага сул, хэрэгжилтэд байнгын хяналт тавих тогтолцоо ойлгомжгүй

Эргэх холбооны дэд тогтолцоо:

1. Хууль эрх зүйн болон салбарын хөгжлийн улмаас дүрэм, журмын зохицуулалтуудад өөрчлөлт орох шаардлага гардаг. Тухайн өөрчлөлтийг цаг тухай бүрт нь хийж чадаагүйгээс дүрэм, журмын хэрэгжилт саардаг.
2. Хэт олон дүрэм, журам нь инновацийг боомилж, шийдвэр гаргах явцыг удаашруулж, хүнд суртлыг нэмэгдүүлдэг.

Асуудал нь системийн доголдлын илрэн гарах шинж ТЭМДЭГ МӨН.



Байгууллагад асуудал үүсгэж буй суурь шалтгааны **94%** нь тухайн байгууллагын **тогтолцоонд**, үлдсэн **6%** нь тухайн байгууллагын **ажилтнуудад** ногдоно.



2. “ДҮРЭМ, ЖУРМЫГ УЯЛДУУЛАХ СУУРЬ ЗАРЧИМ”



Дүрэм, журмуудын харилцан уялдааг бүрдүүлэхэд баримтлах суурь шалгуур хэв шинжүүд:


- ✓ **Журам нь дүрмийн аль нэг тодорхой заалтыг хэрэгжүүлэх зорилготой байвал зохино.**
- ✓ **Журмуудын зорилго нь хоорондоо давхцалгүй байвал зохино.**
- ✓ **Журамд тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолтууд нь дүрмээр тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолтуудтай логикийн хувьд зөрчилдөөнгүй байвал зохино.**
- ✓ **Журмуудын зорилгын хэрэгжилтийг чанартай өгөгдлөөр хэмжих боломжтой байвал зохино.**
- ✓ **Журмын зорилгын хэрэгжилтийг хэмждэг хэмжүүр үзүүлэлт нь дүрмээр тодорхойлсон зорилгын хэрэгжилтийн хэмжүүр үзүүлэлттэй логикийн хувьд зөрчилдөөнгүй байвал зохино.**

Суурь бүтэц:

Энэхүү **Журмын нэр** /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь “Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын **дүрмийн заалтыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүргүүд** оролцогч талуудын үүргүүдийг тогтоож, уялдуулах замаар **журмын зорилгын үр дүн**-д оршино.

Жишээ:

Энэхүү **Оношилгооны журам** /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь “Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын **дүрмийн 9.1.5, 9.1.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд ажилтнууд оношилгоо хийх, ажилтны хийсэн оношилгоог Оношилгооны мониторингийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, оношилгооны бүртгэл хөтлөх** оролцогч талуудын үүргүүдийг тогтоож, уялдуулах замаар **асуудал үүсгэж байгаа шалтгааныг оновчтой тогтооход** оршино.





3. “ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА”



Дүрэм, журмаар байгууллагын тогтолцоог зохицуулж байгаа тул дүрэм, журам нэг бүр нь зорилгоо хэрэгжүүлэх чадвартай тогтолцооны суурь хэв шинжүүдийг хангасан байвал зохино.



Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүрдүүлвэл зохих менежментийн тогтолцоонуудын хэв шинжүүд буюу ТУС-40:



1. Зорилгын тайллын дэд тогтолцоо - **7 хэв шинж**
2. Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо - **6 хэв шинж**
3. Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо - **10 хэв шинж**
4. Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо - **11 хэв шинж**
5. Эргэх холбооны дэд тогтолцоо - **6 хэв шинж**

Дүрэм, журмын хэв шинжийн бүрдлийн түвшингийн үнэлгээ хийх аргачлал

№	Дэд тогтолцоо	Хэв шинжийн тоо	Хэв шинжийн үнэлгээ /1-2 оноогоор/
1	Зорилгын тайллын дэд тогтолцоо	7	14
2	Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо	11	22
3	Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо	6	12
4	Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо	10	20
5	Зорилгын тайллын дэд тогтолцоо	6	12
Нийт		40	80

[ТУС-40 хэв шинжээр үнэлсэн жишээ](#)

Дүрэм, журмын системийн төлөв байдлын үнэлгээний ангилал

№	Ангилал	Тайлбар	Хувь
1	ASA I	Эрсдэлийн нөлөөллийг удирдах чадвартай систем	86.66% < "х" ≤ 100%
2	ASA II	Эрсдэлийн нөлөөллийг тогтвортой даван туулах чадвартай систем	73.32% < "х" ≤ 86.66%
3	ASA III	Эрсдэлийн нөлөөллийг тогтоон барих чадвартай систем	59.98% < "х" ≤ 73.32%
4	ASA IV	Эрсдэлийн нөлөөллийг бууруулах чадвартай систем	46.64% < "х" ≤ 59.98%
5	ASA V	Эрсдэлийн нөлөөлөлд өртөмтгий систем	33.33% < "х" ≤ 46.64%
6	ASA VI	Эрсдэлийн хамгаалалтгүй систем	"х" ≤ 33.33%



ASA - Assessment of System Attributes

Журмаар тогтоосон үүрэг нэг бүрийг чанартай боловсруулсанаар үүргийг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.

№	Нэгж үүргийн чанарт тавигдах шаардлагууд:	Үнэлгээ
1	Үүрэг гүйцэтгэгч нь тодорхой албан тушаалтан байх /Хэн?/	Үүрэг тус бүрийг 1 оноогоор үнэлж нийт үнэлгээг тооцно
2	Үүргийн хүрээнд хийгдэх үйлдэл нь тодорхой байх /хэрхэн?/	
3	Үйлдэлд өртөх объектыг тодорхойлсон байх /юуг?/	
4	Үүргийг гүйцэтгэх нөхцөлийг тусгасан байх. /хэзээ?/	
5	Үүргүүдийг гүйцэтгэснийг нотлох баримт үүсгэдэг байх	



[Үүргийг хэв шинжээр үнэлсэн жишээ](#)

Үүрэгжүүлэлтийн чанарын түвшингийн үнэлгээний ангилал

№	Ангилал	Тайлбар	Хувь
1	DQL-I	Үүрэгжүүлэлтийн чанарын I түвшин	$91\% \leq "x"$
2	DQL-II	Үүрэгжүүлэлтийн чанарын II түвшин	$81\% < "x" \leq 90\%$
3	DQL-III	Үүрэгжүүлэлтийн чанарын III түвшин	$71\% < "x" \leq 80\%$
4	DQL-IV	Үүрэгжүүлэлтийн чанарын IV түвшин	$61\% < "x" \leq 70\%$
5	DQL-V	Үүрэгжүүлэлтийн чанарын V түвшин	$"x" \leq 60\%$

DQL - Duty Quality Level

Журмаар тогтоосон үүргүүдийг АБТ-уудад тусгаснаар журам хэрэгжих нөхцөл бүрдэнэ.



- Чихний хэнгэрэг-Өндөр дуу чимээний даралт хэлбэлзлийг зохицуулдаг
- Чихний дэлбээ- Авиаг цуглуулах
- Дунд чих- Дотор чих рүү дуу авиаг дамжуулах
- Чихний суваг- Чихний даралт, агаарыг зөв зохицуулдаг



ЗАЛУУ СУДЛААЧДЫГ
ДЭМЖИХ САН
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА



TUSS
Tailored Unified System Solution



**Анхаарал хандуулсанд
баярлалаа!**